



Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/10 дугаар тушаалаар “2021 оны эрүүл мэндийн даатгалд хамралтын төлөвлөгөө”-г, 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/13 дугаар тушаалаар “2022 оны эрүүл мэндийн даатгалд хамралтын төлөвлөгөө”-г баталсан байна.

Хэнтий аймагт Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг өөрөө хариуцан төлдөг иргэдийг даатгалд хамрагдалт 2021 онд **53.0** хувь, 2022 онд **69.0** хувьтай байна.

Эрүүл мэндийн даатгалыг өөрөө хариуцан төлдөг иргэдийн хамрагдалт



Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл



Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 2021 **107.7** хувиар биелүүлсэн бол 2022 онд **67.1** хувиар биелжээ.




Хэнтий аймгийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн **2021, 2022** оны орлого болон зарлагын гүйцэтгэлийг харьцуулахад зарлага **2021** онд **15,588.0** сая төгрөгөөр, **2022** онд **20,503** сая төгрөгөөр илүү гүйцэтгэлтэй буюу алдагдалтай байсан бөгөөд зөрүүг эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангийн үлдэгдлээс олгосон байна.





2021 оны байдлаар эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээний санхүүжилтийн тооцоо



Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2021 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Нэхэмжлэлийн хяналтын шалгуур”, ЭМДЕГ-ын мөн оны А/98 дүгээр тушаалаар батлагдсан “Нэхэмжлэлийн хяналт хийх журам”-ын хүрээнд чанар болон төлбөрийн нэхэмжлэлд хяналтыг хийсэн байна.


Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс 2021 онд 11 эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрлөөр 23,514.1 сая төгрөгийн нэхэмжлэлийг шалгаж 21,821.9 сая төгрөгийн санхүүжилт буюу 92.8 хувийг олгохоор хянасан байна.



Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2022 оны 12 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Чанар, төлбөрийн хяналтын журам”, мөн ЭМДЕГ-ын 2022 оны А/139 дүгээр тушаалаар батлагдсан “Нэхэмжлэлийг хянах журам”-ын дагуу төлбөрийн нэхэмжлэлийн хяналтыг хийж санхүүжилтийн гүйцэтгэлийг ЭМДЕГ-т тайлагнаж байна.


Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс **2022** онд нийт **14** эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрлөөр **29,785.6** сая төгрөгийн нэхэмжлэлийг шалгаж **27,668.9** сая төгрөгийн санхүүжилтийг эрүүл мэндийн байгууллагуудад олгохоор хянажээ.

2022 оны байдлаар эрүүл мэндийн байгууллагуудтай тусламж үйлчилгээний санхүүжилтийн тооцоо /сая.төг/





2021 оны Нэхэмжлэлийн хяналтын хасагдал



2021 онд нийт 11 эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрлөөр 343482 иргэний 23,513.6 сая төгрөгийн нэхэмжлэлийг шалгаж 336949 иргэний 21,821.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 6533 иргэний 1,692.1 сая төгрөгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг хассан байна.



2022 онд **13** эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрлөөр **347027** иргэний **29,785.6** сая төгрөгийн нэхэмжлэлийг шалгаж **336882** иргэний **27,668.9** сая төгрөгийн санхүүжилтийг олгож, **10145** иргэний **2,166.7** сая төгрөгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг хассан байна.

2022 оны Нэхэмжлэлийн хяналтын хасагдал






Нийт хасагдсан нэхэмжлэхийн **74.6** хувийг цахимын хяналтын хасагдал эзэлж байгаа бөгөөд үүний ихэнх хувь нь зайлшгүй шаардлагын улмаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан иргэд эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөөгүй байдагтай холбоотой байна.





Эрүүл мэндийн байгууллагуудад дутагдалтай байгаа Их эмчийн тоо



Эрүүл мэндийн байгууллагуудад дутагдалтай байгаа Сувилагч тусгай мэргэжилтний тоо

